

## ОХУ, ГҮРЖ УЛСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Ж.Орхон\**

Орос, Гүрж хоёр улсын харилцаа 16 дугаар зууны эхэн үе Оросын хаан Фёдор Иоановичийн үеэс үндэс сууриа тавьж 17 дугаар зуунд алдарт Георгиевский Трактат гарснаар Гүржийн тархай бутархай 7 улс Оросын эзэнт гүрний бүрэлдэхүүнд багтан оржээ. Тэр үед Орос гүрэн гүрж, абхаз болон бусад үндэстнүүдийг бүрэн устахаас аварсан гэж хэлж болно, үүнд л Орос, Гүржийн эв найрамдалт харилцааны үндэс оршидог. 1921 онд Гүрж Өвөр Кавказын холбоонд нэгдэн /Гүржээс гадна Армени, Азербайджан, тусгаар тогтносон Абхаз зэрэг улсууд/ орсноор хуучнаар ЗХУ-ын нэгэн хэсэг болжээ. Гэвч 1991 онд ЗХУ задран бутарснаар хоёр орны харилцаа хүнд шалгуур туулж байна. Орос-Гүржийн хоёр талын харилцааны гол чиглэлд хоёр улсын хил хамгаалал, гааль болон татварын хэлэлцээр, Гүрж дахь Оросын цэргийн бааз, түүнийг татан буулгах асуудал, гүрж-абхазийн хямрал, Панкиси дахь терроризмын эсрэг үйл ажиллагаа, абхаз болон өмнөд-осетинуудын Оросын иргэншлийн асуудал, үүсэж болзошгүй хямрал /Джавахети, месхи-мусульман, Панкиси/ болон Оросын байр суурь, олон улсын терроризмын эсрэг чиглэсэн Орос-Гүрж-Америкийн гурван талт харилцааны хөгжлийн чиг хандлага, Гүрж улсын бүс нутгийн /НАТО гэх мэт/ хамтын ажиллагааны холбоонд элсэн орох боломж зэрэг асуудлууд багтана.

ОХУ-ын хувьд Гүрж улс стратегийн гол түнш бөгөөд Кавказ дахь геополитикийн хамтрагч учраас уг бүс нутагт исламын экстремизмын тархалт, олон улсын терроризмын идэвхижилттэй тэмцэхэд гол хүчин зүйл гэдэг нь тодорхой. Харамсалтай нь, Орос өдий хүртэл үүнийг дутуу үнэлэн иржээ. Гүрж улсын хувьд ч ОХУ гол хамтрагч бөгөөд ОХУ-гүйгээр өөрийнхөө асуудлыг шийдэх чадваргүй нь илт байна, үүний нэг тод жишээ бол Оросын эрчим хүчний үүсгэвэргүйгээр амьдрах чадвартай эдийн засаг бий болгох магадлал Гүржийн хувьд тун бага байгаа явдал мөн. Гүржийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байх явдал хоёр улсын хувьд бас нэг чухал асуудал. Хэрвээ Гүрж улс 5-6 тусгаар тогтносон улс болон бутарвал эдгээр улсуудад үндэсний-фашист болон ардчилсан бус дэглэм тогтох аюул нүүрлэж болзошгүй юм. Мөн ОХУ-ын үйлдвэрүүдэд түүхий эд нийлүүлдэг Гүржийн аж үйлдвэрүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, ОХУ-ын Өмнөд Европ ба Ойрхи болон Дундад Дорнодын орнуудтай Гүржийн авто болон төмөр зам, агаарын ба далайн замын

\* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

тусламжтайгаар хангагддаг харилцаа, ачаа эргэлт боогдох магадлалтай. Иймд, Гүржийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын хангалт, бүс нутаг дахь цэргийн хямралыг намжаах, олон улсын терроризмтой тэмцэх явдал хоёр улсын ашиг сонирхолд нийцэж байна.

ЗХУ-ын бүрэлдэхүүнд байхдаа Гүрж улс Оростой эдийн засгийн хувьд маш нягт холбоотой байв. 1991 онд хоёр улсын хооронд нийт бараа гүйлгээ 5,5 млрд ам.доллар байсан бөгөөд Армени, Киргиз, Молдави, Таджикистан, Туркмени зэрэг улсуудынхаас илүү байв. Холбооны улсуудын бүрэлдэхүүнд Орос-Гүржийн бараа гүйлгээний хувь хамгийн их бөгөөд 4% хүрсэн бол 2002 он гэхэд энэ үзүүлэлт 40 дахин буурч 160 сая гаруй ам.доллар болж худалдааны хувь зөвхөн 0.5% гэсэн үзүүлэлттэй байна.

Орос-Гүржийн нийт эдийн засгийн хамтын ажиллагаа болон бараа эргэлтийн хэмжээний огцом бууралтын үндсэн шалтгаан дотроос зарим нэгийг авч үзвэл :

- Гүржийн үйлдвэрлэлийн орчин үеийн хүчин чадал маш муу үзүүлэлтэй байгаа бөгөөд ТУХН-ийн орнуудын дунд үндсэн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс хүн амд ноогдох хувиараа хамгийн бага хувьтай байгаа,

- ТУХН-ийн орнуудын дунд Гүржийн тусгаар тогтносон үеийн хугацаанд хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэлийн уналтын хурдац хамгийн өндөр үзүүлэлтэй байна.

- Аж үйлдвэрийн бүтцэд огцом өөрчлөлт гарч 12 жилийн хугацаанд машин үйлдвэрлэх салбарын хувь 2, хөнгөн аж үйлдвэрийн хувь 10 дахин буурсан байна. 1991 он хүртэл ОХУ Гүржтэй хөнгөн аж үйлдвэр болон машин үйлдвэрлэх салбарын бүтээгдэхүүнээр арилжаа хийдэг байсан бол орчин үед эрчим хүчний үүсгэвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр худалдаа хийдэг болсон.

2002 он гэхэд ОХУ-аас Гүрж рүү гаргаж буй экспортын бүтцэд 1991 онтой харьцуулахад онцын өөрчлөлт гараагүй байна. Урьдын адил, Оросын экспортын 49%-ийг хүнсний бүтээгдэхүүн ба хөдөө аж ахуйн түүхий эд, 13% орчим машины үйлдвэрийн бүтээгдэхүүн, 12,6% химийн үйлдвэр, 11,4% эрдэсийн бүтээгдэхүүн зэрэг тус тус эзэлсээр байна. Харин Гүржээс ОХУ руу оруулж буй импортын бүтцэд хүнсний бүтээгдэхүүн болон хөдөө аж ахуйн түүхий эд бараг 85%-ийг эзэлж байна (үүнд архи дарсны бүтээгдэхүүн, рашаан ус, жимс жимсгэнэ, тамхи зэрэг орно), харин машин тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хувь зөвхөн 0.6%-тай байна.

2006 оны 3 дугаар сараас ОХУ Гүржээс дарс болон рашаан оруулахыг хориглосон нь улс төрийн хурцалдал байдлаас үүдэлтэй, тухайлбал, Өмнөд Осетид Оросын энхийг сахиулах хүчин байрлаж буй

гэх мэт. Үүнийг Москва тайлбарлахдаа, ОХУ руу оруулж буй Гүржийн дарсны ихэнхи хувь ариун цэвэр чанарын шаардлага хангахгүй байна гэжээ. Гүржийн эрх баригчид энэ хориг арга хэмжээ улс төрийн шинжтэй, Тбилисийн зүгээс ОХУ-ын геополитикийн сонирхолд нийцэхгүй бодлого явуулж байгаатай холбоотой гэж үзэж байна. Энэ дүгнэлтэй АНУ-ын дарс импортлогч нар мөн санал нэгтэй байна. Гүржийн эрх баригчид дарсны экспортыг АНУ руу хандуулахыг хүсч байгаа боловч энэ явц удааширалттай байгаа нь америкийн хэрэглэгчид гүржийн дарсыг тэр бүр сайн мэдэхгүйтэй холбоотой юм. Гүржийн дарсыг ОХУ төдийгүй АНУ-д экспортлох боломж бүрдүүлэхийн тулд чанарын шаардлагыг дээшлүүлэх механизмыг боловсронгуй болгож хуурамч бүтээгдэхүүнтэй тэмцэх явдал өнөөдрийн тулгамдсан асуудал болоод байна. Одоогийн байдлаар Гүржийн гадаад дотоод зах зээлд хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал газар авч, 2006 оны 5 дугаар сарын 10 гэхэд дарсны 7 үйлдвэрийн үйл ажиллагааг зогсоож, эдийн засгийн цагдаагийн газраас Кутаиси, Зестафони, Вани гэх мэт хотуудад үйлдвэрлэгдэж буй дарсны чанарт шалгалт хийжээ. Үүний үр дүнд гэрийн нөхцөлд дарс үйлдвэрлэн борлуулж байсан хүмүүсийг илрүүлж арга хэмжээ авчээ. Гүржийн хууль тогтоомжид зарим нэг өөрчлөлт оруулах шаардлага гарснаар хуурамч дарс үйлдвэрлэхийг хуулийн дагуу хатуу хориглосон байна. Оросын зах зээл хаагдснаар Гүржийн эдийн засагт томоохон гарз учирч болзошгүй, учир нь гүржийн дарсны 80% оросын зах зээлд борлогддог. Гүржийн Засгийн газраас 2006 оны 9 сар гэхэд дарс үйлдвэрлэгч болгон бүртгэлийн сертификат авах шаардлага тавьж байгаа нь чанарын стандартыг дээшлүүлэх зорилготой алхам болж байна. Бас нэг чухал алхам бол дарсны үйлдвэрлэлд хяналтын систем бий болгож, энэ нь цаашдаа хуулийн дагуу үйлдвэрлэгдсэн дарс болгоныг хянах боломж олгох юм.

### ОХУ Гүрж улстай хийж буй бараа эргэлт (2002 оны үзүүлэлтээр)

	Экспорт		Импорт		Бараа эргэлт	
	мянг. \$	%	мянг. \$	%	мянг. \$	%
Хүнсний бүтээгдэхүүн ба Хөдөө аж ахуйн түүхий эд	44734	48.9	58116	84.4	102850	64.2
Эрдэс баялаг	10371	11.4	3191	4.6	13562	8.5
ҮҮНД:						
Түлш эрчим хүчний бүтээгдэхүүн	10310	11.3	955	1.4	11265	7.0
Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн болон каучук	11578	12.6	558	0.8	12136	7.6
Мод болон целлюлоз, цаасан бүтээгдэхүүн	3175	3.5	87	0.1	3262	2.0
Нэхмэл, бөс бараа, гутал	152	0.2	59	0.1	211	0.1
Шил шаазан элзэл.	2354	2.6	14	-	2368	1.5
Гипс, цементэн бүтээгдэхүүн						
Металл, металл бүтээгдэхүүн	5367	5.8	2414	3.5	7781	4.8
Машин, тоног төхөөрөмж, зам тээврийн хэрэгсэл	11586	12.7	4186	6.1	15772	9.8
Бусад бараа	2052	2.3	294	0.4	2346	1.5
Нийт	91369	100	68919	100	160288	100

Гүржийн ирээдүйн хөгжил эхний ээлжинд эдийн засгийн хараат бус нөхцөлд дэлхийн эдийн засгийн үйл явцад хэрхэн оролцохоос шалтгаална. Энэ нь дотоодын болон гадаад зах зээлийн харилцан уялдах түвшингээр тодорхойлогдох юм. Гүржийн гадаад харилцаа харилцан адилгүй, ихэнхи хувь нь хуучин холбооны улсуудад хамаарагддаг хэвээр байна.

1999 оны 10 дугаар сарын 6-нд гурван жил ярилцсаны эцэст Гүрж улс Дэлхийн Худалдааны Байгууллагын 136 дахь албан ёсны гишүүнээр элсэн оров. 1997 оны 1 дүгээр сараас эхлэн гаалийн суурь тарифийг 12-5% болтол бууруулж, экспортын бүх хязгаарлалт болон гадаад эдийн засгийн үйл ажиллагааны лицензийг хүчингүй болгох хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний тарифын дээд хэмжээг 25%, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний тарифыг 15%-иар тогтоожээ.

Гүрж улс ДХБ-ын гишүүн болсон явдал түүний нийгэм, эдийн засгийн хөгжил болон ТУХН-ийн бусад орнуудтай харилцах харилцаанд нөлөөлөх магадлалтай гэж шинжээчид үзэж байна. Импортын өндөр хувьтай улсын хувьд Гүрж импортын хэмжээг бууруулсан нөхцөлд үндэсний эдийн засагт хүндрэл дагуулах магадлалтай, учир нь импортын татвар буурснаар төсвийн орлогын хувь буурч, энэ нь яваандаа олон улсын зээл олгогчдоос ерийн хараат байдалд ороход хүргэж болзошгүй юм. Улс хоорондын банкны мэдээлснээр, 1999-2002 онуудад Гүржийн олон улсын байгууллага болон банкуудын өмнө хүлээх үүрэг 170-190 сая ам.доллараар өссөн байна.

Гүржийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар муулайгаас дотоодын зах зээлийг өргөжүүлснээр, гадаадын бараа үйлдвэрлэгчид түрэн орж ирж, энэ нь эцэстээ аж үйлдвэрийн зарим салбар үгүй болох аюултай бөгөөд ТУХН-ийн орнуудтай харилцан наймаа хийхэд нөлөөлөх үр дагавартай.

Гүржийн ТУХН-ийн орнуудаас экспортын үндсэн түншүүд гэвэл: ОХУ (50.9%), Туркменистан (20%), Армени (8.6%), Украин (8.1%), Азербайджан (7.3%) байдаг бол импортын түншүүд нь ОХУ (36.4%), Азербайджан (29.2%), Украин (19.7%), Туркменистан (7%) зэрэг орнууд байдаг байна.

ОХУ болон Гүржийн хоорондох асуудлыг шийдэхэд эдийн засгийн хамтын ажиллагаа ба тус улсуудын эдийн засгийн сонирхлыг урьтал болгох шаардлагатай. Үүнийг ч ажил хэрэгч хүмүүс ойлгож байна. Иймд “Оросын эрчим хүчний нэгдсэн сүлжээ” хувь нийлүүлсэн үйлдвэр ТУХН болон Хар далайн эргийн улсуудад нэгдсэн эрчим хүчний сүлжээ байгуулахаар эрмэлзэж байна. Энэ чиглэлд гүржийн талтай эрчим хүчний салбарт хамтран “Кавкасиони” нэртэй цахилгаан дамжуулах шугамыг сэргээн ажиллуулж эхэллээ. Ирээдүйд Хар далайн эргийн дагуу

цахилгаан эрчим хүч дамжуулахын зэрэгцээ шугамуудыг барьж байгуулахаар төлөвлөж байна. (Абхазийн хямралыг намжаасны дараа)

Хоёр улсын хооронд бараа эргэлтийн хувь бага байгаагийн үндсэн шалтгаанд: төмөр замын тогтвортой холбоо байхгүй (Абхазийн хямралаас болж Гүрж улс ОХУ-тай шууд харьцах боломжгүй байна), мөн зээлийн болон эргэлтийн хөрөнгө дутагдалтай, эрх зүйн хэм хэмжээний үндэс, санхүүгийн үйлчилгээ болон татвар оногдуулалтын туршлага учир дутагдалтай байгаа зэрэгт оршино. Эрх зүйн хэм хэмжээний үндэс суурьт байгаа зарим зөрчилдөөнийг шийдвэрлэх шаардлага үүнээс үүдэн гарч байна. Орос-Гүржийн хооронд 100-аад хэлэлцээр байдаг боловч, ихэнхи нь ямар ч үр дүн өгөхгүйн дээр, зарим нь хэрэгжих шатандаа оролгүйгээр хуучирч шинэчлэх шаарлагатай болоод байна. Үүгээр зогсохгүй, 1994 онд батлагдсан “Энх тайван, хамтын ажиллагааны тухай Гэрээ” өдий болтол Оросын Думаар батлагдаагүй байна.

Гүрж улс өөрийн түүхий эд, эрдэсийн баялагтай орон бөгөөд энэ нь түүний аж ахуйн цаашдын хөгжилд их хувь нэмэр болох юм. Тус улсад нефтийн 14 орд газар ашиглагддаг бөгөөд түүний идэвхитэй нөөцийн 50% нь нийслэл Тбилиси хотын ойролцоо төвлөрдөг. Аж ахуйн чиглэлээр ашиглагддаг А+В+С ангилалын нефтийн нөөц 1998 оны 01 сарын 01-ний байдлаар 59.3 сая тонн, нүүрсний нөөц 406.0 сая тонн байна. Мөн марганцын хүдэрээр баялаг бөгөөд А+В+С ангилалын нөөц 199.7 сая тонн, С2 ангилалын - 15.1 сая тонн нөөцтөй. Тус улсад аж ахуйн зориулалтын зэс, хар тугалга, цайр, молибден, мөнгөн ус, хүнцэл, барит, бентонитын шавар зэргийн нөөц байдаг байна. Эдгээрийг олборлож ашиглахын тулд бусад улсаас, юуны өмнө ОХУ-аас хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах нь чухал юм.

Бас нэг хамтран ажиллах салбар бол эрчим хүчний салбар бөгөөд хоёр орны эрчим хүчний системийн зэрэгцээ ажиллагааг нөхөн сэргээж, Гүржийн нутаг дэвсгэрээр гуравдагч орнууд руу эрчим хүчийг гаргах асуудал юм. Үүний тулд Гүржийн нутаг дэвсгэр дээр Оросын түлш-эрчим хүчний нөөцөд тулгуурлан эрчим эрчим хүч гаргаж авахаар эрчим хүчний хэсэг байгуулж байна.

Гүржийн нефтийн орд газрыг сэргээж, нефтийн нэмэлт хайгуулын ажилд Оросын мэргэжилтнүүд оролцож, тусгай тоног төхөөрөмж нийлүүлэхээр болжээ. ОХУ-ын Эрчим хүчний Яамтай хамтран дамжин өнгөрөх хийн хоолой болон бусад объектуудыг сэргээн босгох нь Гүржийн хувьд эдгээр объектууд өндөр ашигтай объект болох нь тодорхой. Баку-Тбилиси-Джейхан нефтийн хоолой байгуулах явдал

болон эдгээр арга хэмжээнүүд нь одоо байгаа эрчим хүчний хомсдлыг арилгахад их нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

ОХУ болон Гүржийн эдийн засгийн хамтын ажиллагааны цаашдын хөгжилд 1997 оны 1 дүгээр сард Тбилиси хотноо, мөн 2002 оны 1 дүгээр сард Москва хотод тус тус хуралдсан Орос-Гүржийн эдийн засгийн хамтын ажиллагааны Комиссийн гаргасан шийдвэр, Москва хотын Засгийн газар болон Гүржийн Гүйцэтгэх засаг захиргааны хооронд 1998 оны 12 дугаар сарын 26-нд байгуулсан “Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техник болон нийгмийн ухааны салбарт хамтран ажиллах Гэрээ”; 2002 оны 1 дүгээр сарын 16-нд Москва хотын Засгийн газар болон Гүржийн Гүйцэтгэх засаг захиргааны хуралдааны комиссийн гаргасан Протокол зэрэг баримт бичгүүд их ач холбогдолтой. Эдгээр баримт бичгийн дагуу ОХУ Гүрж рүү хөнгөн ба хүнд машин тэрэг, трактор, шингэрүүлсэн хий, улаан буудай, мод, цаас болон бусад бүтээгдэхүүн гаргахаар болсон бол Гүржээс ОХУ руу зэсийн баяжмал, марганцын хүдэр, дарс, оргилуун дарс, коньяк, цай, рашаан ус, жимс зэргийг гаргахаар болсон байна.

ОХУ болон Гүрж улсын хооронд үр ашигтай хамтын ажиллагааны механизмыг бий болгох үндсэн зорилгод хоёр талын худалдааны татварын буюу татварын бус хязгаарыг халах, үйлдвэр болон байгууллагуудын хооронд эдийн засгийн үр өгөөжтэй холбоог сэргээх, улс хоорондын нэгж байгуулах, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа болон зээл-мөнгөний харилцан тохиролцсон харилцаа ба эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа зэргийг бий болгох шаардлагатай.

2003 оны эхэн үеэс Орос-Гүржийн харилцаанд зарим нэг нааштай алхам гарсны нэг жишээ бол 2003 оны 3 дугаар сарын эхэнд Сочи хотноо болсон хоёр орны ерөнхийлөгчдийн уулзалт юм. Энэ уулзалтын үр дүнд Абхази дахь зэвсэгт хямралыг зохицуулах зарим арга хэмжээ авахаар болсноос дурьдвал дүрвэгсэд болон шилжин суугчдыг Абхазийн Галлийн дүүрэгт буцаах, хямралын бүс нутгийн эдийн засгийг сэргээн босгох, Оросын энхийг сахиулах хүчний статусыг тодорхойлох, эдийн засгийн хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх арга зам боловсруулах зэргийг нэрлэж болно. Мөн Орос-Гүржийн харилцааны үндэс болсон хоёр улсын хоорондох хэм хэмжээний Гэрээний төслийн хэлэлцээрийг түргэсгэхэд онцгой анхаарал тавьж байна.

Уг бүс нутгийн хувьд Оросын байр суурь нээлттэй бөгөөд үр бүтээлтэй шинж агуулсан нь Гүржийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг дэмжиж, Абхазийн ард түмний үндэсний тусгаар тогтнох эрхийг хүлээн зөвшөөрөх, аливаа маргаантай асуудлыг аль нэгэн тал цэргийн

хүчээр шийдэхийг буруутгах зэргээр тодорхойлогдоно. Үүнийгээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлтэй хамтран хэрэгжүүлэхийг эрмэлзэж, гүрж-абхазийн хямралыг намжаахаар энхийг сахиулах үйл ажиллагаа явуулахаар 1994 оны 7 дугаар сарын 27-нд НҮБ-ийн Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрийг гаргуулж чаджээ.

Гүржийн улс төрийн байдал ерөнхийдөө тогтворгүй, эдийн засгийн хувьд сул дорой байгаа нь өөрчлөн шинэчлэлийн үйл явцын үр дүн бага, гэмт хэрэг, авилгал хэзээ хахууль маш их газар авсантай холбоотой. Бусад Кавказын улсуудын адил, Гүржийн хүн амын ихэнхи хувь сайн сайхан амьдарч, ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор гадаад руу дүрвэж байна. Мөн Сванети, Өрнөд Гүрж, Месхети, Ахалкалаки, Панкиссын хавцал зэрэг газруудын байдал тогтворгүй байна. Чечений тогтворгүй байдал Гүржийн дотоод байдалд их нөлөөтэй. Яагаад гэвэл чечений дүрвэгсэдийн цуваа ихсэж, алан хядагчид хилээр чөлөөтэй зөрчиж байгаа нь Гүржийн хил орчмын хүн амын угсааны тэнцвэр алдагдахад хүргэж болзошгүй аюултай.

ОХУ, Гүрж хоёр улс төр, эдийн засгийн чиглэлд хамтран ажиллаж ирсэн, тухайлбал Гүрж Улс ТУХН-ийн орнуудын бүрэлдэхүүнд ордог, мөн хуучин ЗХУ-ын орон зайд бий болсон бусад олон улсын байгууллагад Оросын оролцоотойгоор нэгдсэн. Гэвч уг хамтын ажиллагааг ажил хэрэгч шатанд оруулах нь өнөөгийн тулгамдсан асуудал болоод байна. Үүний тулд улс төрийн зориг гаргах шаардлагатай байгаа боловч одоогоор энэ нь хэрэгжихгүй байгаа нь тодорхой байна.

Орос-Гүржийн нийгмийн салбар дахь хамтын ажиллагаа хоёр орны олон жилийн соёлын харилцаанаас улбаатай. Гүржийн нийгмийн ухаан, уран зохиол, урлагийн нэрт зүтгэлтнүүд Оросын соёл урлагт их хувь нэмэр оруулсан. Үүнд яруу найрагч А.Г.Чавчавадзе, В.Пшавела, Н.Бараташвили, зохиолч И.Г.Чавчавадзе, А.Р.Церетели, А.М.Казбеги, зураач, уран барималч, хөгжимчид зэргийг дурьдаж болно. Ихэнхи нь Оросын их дээд сургуулийг дүүргэсэн байдаг. Мөн Оросын урлагийн “од” болсон З.Соткилава, Н.Ананишвили, Н.Брегвадзе, Э.Шенгелая, Г.Данелия, В.Кикабидзе зэрэг олон хүмүүс өдий болтол алдар нэрээ дуурсагсаар байгаа. 2000 оны 12 дугаар сард ОХУ болон Гүржийн Соёлын Яамдуудын хооронд хамтран ажиллах Гэрээ байгуулагдсан байна. Театруудын хооронд уран бүтээлийн хамтын ажиллагаа хөгжсөөр байгаа. З.Палиашвилигийн нэрэмжит Дуурь бүжгийн театрын тайзнаа Оросын Эрдмийн Их театрын болон Санк-Петербургийн Марины театрын нэрт жүжигчид нэг бус удаа тоглолт хийсэн. Мөн хоёр

орны уран бүтээлчид, жүжигчид, урлагийн байгууллагууд байнга айлчлан тоглолт хийсээр байна. Жишээлбэл: Гүржийн А.С.Грибоедовын нэрэмжит оросын театр Москва хотноо айлчлан тоглосон, мөн Москвад Аджарийн соёлын өдрүүдийг зохион байгуулсан гэх зэрэг арга хэмжээнүүдийг дурьдаж болно.

Оросын дээд боловсролын тогтолцоо гүржийн залуучуудын дунд их нэр хүндтэй хэвээрээ байгаа бөгөөд ОХУ-ын их дээд сургуулиудад 300 гаруй гүржийн оюутан аспирантууд төсвийн үндсэн дээр суралцаж байна. Боловсролын салбарт хамтран ажиллах Орос-Гүржийн салбар хоорондын шинэ хэлэлцээр гарахад бэлэн болсон. Орос-Гүржийн харилцааны түүх, соёлын агуу их потенциал нь орчин үеийн улс төрч, шинжээчдийн хувьд Гүржтэй эв найрамдалт, сайн хөршийн харилцааг сэргээхэд мэдэгдэхүйц эерэг хүчин зүйл болох юм.

Гэвч түүх-соёлын уламжлалт холбоотой хоёр орны харилцаанд үл итгэлцэл бий болж байгаа нь Оросын улс төрийн элитийн дунд олон улсын шинж чанартай, ялангуяа АНУ болон НАТО-той ОХУ-ын ашиг сонирхол хөндсөн асуудал шийдэхэд Гүржийн дэмжлэг туслалцаанд найдах итгэл байхгүй гэсэн хатуу ойлголт нэгэнтээ газар авсанаар илэрч буй. Зарим шинжээчид Орос Тбилисийг стратегийн түнш биш, зөвхөн түр хамтрагч гэж үзэх үзэлтэй хэвээр байдаг бол зарим нь Гүржийн удирдлага ОХУ-ыг өөрийн нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг халгалах, дотоодын улс төрийн байдлыг тогтворжуулахад нэг үгээр хэлбэл тактикийн зорилгод ашиглах эрмэлзэлтэй гэж үзэх хүмүүс ч байна. Стратегийн хувьд Гүрж АНУ болон НАТО-той ойртох бодлого баримталж байгаа боловч нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлаа орчин цагт ОХУ-ын тусламжгүйгээр сэргээх боломжгүй учраас уг бодлогоо харахан хэрэгжүүлж чадахгүй байгаа.

Сүүлийн үед Гүрж, Оросын харилцааны асуудал улам хурцалмал байдалтай байна, учир нь 2006 оны 9 дүгээр сарын 27-нд Гүржийн Дотоод явдлын яамны сайд Вано Мерабишвили Өвөр Кавказ дахь Оросын цэргийн бүлгийн дөрвөн офицер, Гүржийн 10 гаруй иргэнийг тус яамны сөрөх тагнуулын газар баривчлав хэмээн мэдээлснээс эхэлсэн билээ. Түүний хэлснээр баривчлагдсан хүмүүс Гүржийн нутагт тагнуул хийж байжээ. Энэхүү явдлыг Оросын тал тун таагүй хүлээн авч, Оросын цэргийн албан хаагчдыг ул үндэсгүйгээр баривчилсан, энэ бол илэрхий өдөөн хатгалга хэмээн мэдэгдэв. Оросын Гадаад хэргийн яамны сайд Сергей Лавров Оросын цэргийн албан хаагчдыг баривчилсан нь ээлжит өдөөн хатгалга, Оросын эсрэг бодлогын илрэл гэж дүгнэв. Түүгээр ч барахгүй Оросын ерөнхий сайдын орлогч, Батлан хамгаалах яамны сайд Сергей Иванов



Гүржийн эрх баригчдын ажиллагаа нь төрийн терроризм гэж мэдэгдэв. Хэсэг хугацааны дараа Оросын офицеруудыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагаар дамжуулан Оросын талд хүлээлгэн өгсөн боловч Кремль Гүржийн эсрэг хатуу арга хэмжээ авлаа. Тухайлбал, Орос Гүржийн хоорондын агаарын, усан замын, авто замын, төмөр замын тээвэр, шуудангийн харилцаа, мөнгө гуйвуулах ажилбарыг бүрэн зогсоолоо. Үүний өмнө Гүржээс дарс, рашаан зэрэг хүнсний бүтээгдэхүүн импортлохыг зогсоосон байсан юм. Гүржийн иргэдэд ОХУ-д зорчих виз олгохыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан байна. Эдүгээ Орост Гүржийн сая гаруй иргэн оршин суудаг. Харин Гүрж 4,6 сая хүн амтай. Мөнгөн гуйвуулга хийхийг хязгаарлавал Орост амьдарч буй гүржүүдийн эсрэг авах эдийн засгийн хориг арга хэмжээ болох юм. Орост амьдардаг гүржийн бизнесменүүд багагүй хэмжээний валютыг нутаг руугаа хөрвүүлдэг. Энэ нь зогсвол Гүржийн эдийн засагт тодорхой хэмжээний цохилт болох юм.

Түүнчлэн Москва Гүржид эрчим хүч нийлүүлэхээ зогсоох асуудал ч яригдаж байна. Байгалийн хий нийлүүлэхээ зогсоовол Гүрж Оросоос энэ тал дээр бүрэн хараат байдаг учраас тус улсын байдал улам хүндэрч жирийн иргэд хохирох учиртай.

Оросын улс төрчид, ялангуяа улсын Думын депутатууд Гүржийн талаар улам хатуу хориг арга хэмжээ авах хэрэгтэй гэж мэдэгдсээр байна. Ингэхдээ Гүржийн эрх баригчид АНУ-тай зөвшилцөхгүйгээр тийм эрс арга хэмжээ авахгүй байсан гэдгийг тэмдэглэж, Гүржийн өр төлбөрийг хүртэл сөхөж тавих болов. Одоогоор Гүрж Орост 147 сая долларын өртэй. Улс төрийн маш ээдрээтэй асуудлуудыг ч босгож ирэх болов. Зарим депутатууд дангаараа тусгаар тогтнолоо зарласан Абхаз, Өмнөд Осетийн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх арга хэмжээ боловсруулах, тэдгээрийг тусгаар тогтносон улсын хувиар зөвшөөрөх горимд шилжих хэрэгтэй гэж мэдэгдэж байна. Ер нь Оросын Дум Гүржийн эсрэг нэмж янз бүрийн арга хэмжээ, юуны өмнө санхүү эдийн засгийн чанартай арга хэмжээ авах бололтой байна. Гүржийн эсрэг авсан дээр дурдсан хориг арга хэмжээ тус улсын эдийн засагт хүнд тусах нь ойлгомжтой. Гүржид Оросоос янз бүрийн шугамаар жилдээ 1-2 сая доллар гуйвуулгаар орж ирдэг байна. Орос, Гүржийн эсрэг ийм эрс арга хэмжээ авах болсон нь зөвхөн дөрвөн цэргийн албан хаагчийг баривчилсан будлиантай холбоотой биш. Гүржийн ерөнхийлөгч М.Саакашвили тус улсын төрийн тэргүүн болсон цагаасаа эхлэн илэрхий барууны тал баримталсан чиг шугам явуулж, АНУ-ыг аялдан дагаж, НАТО-д элсэхийг урьдал болгож байгаа нь Оросын таашаалд

яавч нийцээгүй. Гүрж НАТО-г ардчилал, тогтвортой байдлын баталгаа гэж үздэг бол Орос НАТО-г өргөжүүлэхийг ямагт эсэргүүцэж ирсэн. Гүржийн талын шаргуу шаардлагаар тус улс дахь Оросын цэргийн баазыг гаргах болсон /гэрээ ёсоор 2008 онд Оросын цэрэг Гүржээс бүрэн гарна/ бас Абхаз, Өмнөд Осетийн тогтвортой байдлыг хангаж буй энхийг сахиулагчдыг ч гаргаж, яваандаа өрнөдийн энхийг сахиулагчдаар солих, ингэснээр Оросын цэргийн оролцоог бүрэн шахан гаргах, ерөөсөө Оросын нөлөөнөөс ангижрах бодлого баримталж байна гэж Оросын эрх баригчид үзэж байгаа нь тодорхой харагдаж байна. Бас Орос улс Кавказын бүс нутагт нөлөөгөө алдахгүй гэдгийг тод томруун харууллаа. Орос бол их гүрэн гэдгээ ч дэлхий нийтийн өмнө илэрхийллээ. Оросын ерөнхийлөгч В.Путин “Оростой өдөөн хатгалга, дарамт шахалтын хэлээр ярихгүй байхыг” бусад оронд ялангуяа Гүржид анхааруулжээ. Орос, Гүржийн харилцаа цаашид хэрхэн өрнөхийг цаг хугацаа харуулна, гэвч хоёр улсын харилцааг хэвийн голдиролд ороход гуравдагч этгээдийн зуучлал хэрэггүй гэж Оросын эрх баригчид албан ёсоор үзсээр байна.

### **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

1. Сборник Российско-Грузинский диалог. Под ред. С.В.Кортунова, С.Л.Ознобишева. Фонд им. Фридриха Эберта. Комитет внешнеполитического планирования. Иститут стратегических оценок.  
[http://www.netda.ru/politic/gruzia/rg\\_dialog\\_r.htm](http://www.netda.ru/politic/gruzia/rg_dialog_r.htm)
2. Грузия пытается переориентировать экспорт винной продукции. Д.Тайнан. <http://www.eurasianet.org/eurasianet/russian/departments/business/articles/eav...05.10.2006>
3. Гүрж, Оросыг донсолгосон өдрүүд. 05.10.2006.  
<http://www.montsame.mn/newsdetailp.php>
4. Россия-Грузия: очередной обмен “любезностями” //Что дальше? Б.Львов, полит.обозреватель. URL документа:  
<http://ossetia.ru/politics/russia-georgia>
5. Москва нулимсанд дургүй. Зууны мэдээ.2006-10-06.